



## ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН РЕКТОРЫН ТУШААЛ

2024 оны 09 сарын 19 өдөр

Дугаар А/277

Улаанбаатар хот

### Шагнал урамшууллын журам шинэчлэн батлах тухай

Монгол улсын Дээд боловсролын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2, ШУТИС-ийн дүрмийн 4.9.15, 4.9.16, ШУТИС-ийн Ректорын зөвлөлийн 2024 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Шагнал урамшууллын журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Шинэчлэн батлагдсан “Шагнал урамшууллын журам”-ыг нийт багш ажилтнуудад танилцуулж, мөрдөж хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ректорын ажлын алба (Н.Ганзориг), Хүний нөөцийн алба (Д.Мягмарсүрэн), бүрэлдэхүүн, салбар сургууль, нэгжийн захирлуудад үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан ШУТИС-ийн захирлын 2010 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 116 дугаар тушаалаар баталсан ШУТИС-ийн профессор багш, ажилтан ажилчдыг шагнаж урамшуулах журмыг хүчингүйд тооцсугай.

4. Энэхүү тушаалыг 2024 оны 09 дүгээр сарын 03-ны өдрөөс мөрдсүгэй.

РЕКТОР  Т.НАМНАН

367040516

ШУТИС-ийн Ректорын 2024 оны 09 дүгээр сарын  
19-ний өдрийн 247 дугаар тушаалын хавсралт



	Шагнал урамшууллын журам ШУТИС-ХН-ЖУ02	Эхний хэвлэлт	2010.04.02
		Өөрчилсөн огноо	2019.09.25
		Өөрчилсөн огноо	2021.11.23
		Өөрчилсөн огноо	2024.09.03
		Өөрчлөлтийн дугаар	3

## ШАГНАЛ УРАМШУУЛЛЫН ЖУРАМ

Боловсруулсан:

ХҮНИЙ НӨӨЦИЙН АЛБА

Хянасан:

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН АЛБА

Дэмжсэн:

ШУТИС-ийн РЕКТОРЫН ЗӨВЛӨЛ

Баталсан:

ШУТИС-ийн РЕКТОР



## АГУУЛГА

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

**ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ**

**ГУРАВ. МОНГОЛ УЛСЫН ЦОЛ ХҮРТЭЭХ, ОДОН МЕДАЛЬ, ЗАСГИЙН ГАЗРЫН  
БОЛОН ТӨРИЙН БУСАД БАЙГУУЛЛАГЫН ШАГНАЛД НЭР ДЭВШҮҮЛЭХ**

**ДӨРӨВ. ШУТИС-ИЙН ШАГНАЛД НЭР ДЭВШҮҮЛЭХ, ШИЙДВЭРЛЭХ**





ШУТИС-ийн Ректорын 2024 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн 14 дугаар тушаалын хавсралт

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү журмын зорилго нь боловсрол, шинжлэх ухаан, технологийн талаарх төрийн бодлого, хөтөлбөр, ШУТИС-ийн хөгжлийн бодлого, стратеги, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, боловсрол, шинжлэх ухааны салбарыг хөгжүүлэх үйл хэрэгт үр бүтээлтэй ажиллаж, тодорхой амжилт гаргасан ШУТИС-ийн багш, ажилтнуудыг Монгол Улсын цол хүртээх, одон, медаль, Засгийн газрын болон төрийн бусад байгууллагын шагналд нэр дэвшүүлэх, уламжлах, ШУТИС-ийн шагналд нэр дэвшүүлэх, шагнуулах тухай хүсэлт саналыг шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

### ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

- 2.1 Монгол Улсын цол хүртээх, одон, медаль, Засгийн газрын болон төрийн бусад байгууллагын шагналд нэр дэвшүүлэх, уламжлах, ШУТИС-ийн шагналд нэр дэвшүүлэх, шагнуулахаар дэмжсэн, шагнагдсан иргэн хамаарна.

### ГУРАВ. МОНГОЛ УЛСЫН ЦОЛ ХҮРТЭЭХ, ОДОН, МЕДАЛЬ, ЗАСГИЙН ГАЗРЫН БОЛОН ТӨРИЙН БУСАД БАЙГУУЛЛАГЫН ШАГНАЛД НЭР ДЭВШҮҮЛЭХ

- 3.1 Нэр дэвшигч нь Монгол Улсын цол, одон, медалийн холбогдох эрэмбийн дагуу өмнөх шагнал хүртсэнээс хойш үр бүтээлтэй ажиллан тодорхой амжилт гаргасан, ажлын амжилт бүтээл нь өмнө шагнал авсан түвшингээсээ ахисан, холбогдох байгууллагын шагналын дүрэм, журамд заасан болзол, шалгуурыг тус тус хангасан байвал зохино.
- 3.2 Засгийн газрын шагналаар шагнагдсан иргэнийг Монгол Улсын одон, медалиар шагнуулахаар, Монгол Улсын одон, медалиар шагнагдсан иргэнийг Монгол Улсын цол хүртээхээр тус тус нэр дэвшүүлнэ.
- 3.3 3.1, 3.2-т заасан болзол, шалгууруудыг хангасан, Монгол Улсын цол хүртээх, одон, медаль, Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан буюу хүндэт тэмдэг, яамдын шагналаар шагнуулах хүмүүсийг анхан шатанд дараах хурлаар хэлэлцэн нэр дэвшүүлнэ. Үүнд:
  - 3.3.1 Бүрэлдэхүүн, салбар болон харъяа сургууль, нэгжийн багш, ажилтныг тухайн бүрэлдэхүүн, салбар, харъяа сургууль, нэгжийн захирлын зөвлөлийн хурлаар;
  - 3.3.2 Их сургуулийн захиргааны ажилтныг тухайн газар, алба, нэгжийн хамт олны хурлаар;
- 3.4 Хурлын ирц 75%-иас доошгүй байх шаардлагатай бөгөөд хуралд оролцогчдын 80-аас дээш хувь нь шагналд нэр дэвшүүлэхийг дэмжсэн хурлын тэмдэглэл, шагналд нэр дэвшигчийн мэдээлэл, анкет зэргийг шагнуулах хүсэлтийн хамт Хүний нөөцийн асуудал хариуцсан захиргааны нэгжид ирүүлнэ.
- 3.5 Хүний нөөцийн асуудал хариуцсан нэгж материалыг хянан нэгтгэж, ШУТИС-ийн Захиргааны зөвлөлөөр хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ.
- 3.6 ШУТИС-ийн Захиргааны зөвлөлөөс дэмжигдсэн иргэний ажил байдлын тодорхойлолтод Ректор гарын үсэг зурж, ШУТИС-ийн тамга дарна.



ШУТИС-ийн Ректорын 2022 оны 19-дүгээр сарын 19-ний өдрийн 47 дугаар тушаалын хавсралт



- 3.7 Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнуулахаар дэвшүүлсэн нэр дэвшигчийн бүрдүүлсэн шагналын материалыг хамт тухайн тэмдэглэлт өдөр, ой болохоос 1 жилээс доошгүй хугацааны өмнө сум, дүүргийн Засаг даргад уламжилна.
- 3.8 Засгийн газрын болон төрийн бусад байгууллагын шагналаар шагнуулах нэр дэвшигчийн материалыг тухайн байгууллагын шагналын дүрэм, журамд заасны дагуу бүрдүүлж, тухайн тэмдэглэлт өдөр, ой болохоос 1 сараас доошгүй хугацааны өмнө холбогдох яам, байгууллагад хүргүүлнэ.
- 3.9 Монгол Улсын цол, төрийн шагнал хүртсэн, одон, медалиар шагнагдсан хүмүүст нийт хамт олныг хамарсан хурал зөвлөгөөн, баярын арга хэмжээ болон Ректорын зөвлөлийн хурал, бүрэлдэхүүн, салбар сургуулийн хурал, цуглаан дээр баяр хүргэж, хүндэтгэл үзүүлнэ.
- 3.10 Монгол Улсын цол, төрийн шагнал хүртсэн иргэнд их сургуулийн дурсамж, мөнгөн аягатай цагаан идээний дээж, хадгийн хамт, Монгол Улсын одон, медалиар шагнагдсан иргэнд монгол аягатай цагаан идээний дээж, хадгийн хамт тус тус гардуулан хүндэтгэл үзүүлэх бөгөөд дурсамжтай холбогдох зардлыг төвлөрсөн арга хэмжээний зардлаас, холбогдох бусад зардлыг шагнагдсан иргэний харъяалах нэгж хариуцан гаргана.
- 3.11 Засгийн газрын шагнал, яамдын шагналын дагалдах мөнгөн урамшууллыг шагнуулахаар тодорхойлолт гаргасан бүрэлдэхүүн, салбар сургууль, нэгж холбогдох яамны шагнал олгох журамд заасны дагуу шийдвэрлэнэ.

#### **ДӨРӨВ. ШУТИС-ИЙН ШАГНАЛД НЭР ДЭВШҮҮЛЭХ, ШИЙДВЭРЛЭХ**

- 4.1 ШУТИС нь дараах цол, шагналтай байна. Үүнд:
  - 4.1.1 ШУТИС-ийн Хүндэт доктор цол;
  - 4.1.2 ШУТИС-ийн Хүндэт профессор цол;
  - 4.1.3 ШУТИС-ийн Хүндэт өргөмжлөл;
  - 4.1.4 ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн шагнал;
  - 4.1.5 Ректорын нэрэмжит шагнал;
  - 4.1.6 Бүрэлдэхүүн, салбар сургуулийн шагнал.
- 4.2 ШУТИС-ийн Хүндэт доктор болон Хүндэт профессор цол олгохтой холбогдсон харилцааг "ШУТИС-ийн эрдмийн болон хүндэт цол олгох журам"-аар зохицуулна.
- 4.3 ШУТИС-ийн дээд шагнал болох "ШУТИС-ийн Хүндэт өргөмжлөл" шагналыг тус их сургуулийг болон тухайн салбар, шинжлэх ухааныг хөгжүүлэхэд онцгой амжилт гаргаж, үнэтэй хувь нэмэр оруулсан иргэнд олгоно.
- 4.4 ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн шагналаар тус их сургуулийн бүрэлдэхүүн, салбар, харьяа сургууль, нэгжийн багш, ажилтнуудыг, Ректорын нэрэмжит шагналаар тус их сургуулийн бүрэлдэхүүн, салбар, харьяа сургууль, нэгжийн багш, ажилтан, иргэнийг, бүрэлдэхүүн, салбар сургуулийн шагналаар тухайн сургуулийн багш, ажилтан, иргэнийг тус тус шагнаж урамшуулна.
- 4.5 Жил бүрийн багш нарын баяр, шинжлэх ухааны ажилтны өдөр, шинэ жилийн баяр болон их сургууль, бүрэлдэхүүн, салбар, харьяа сургууль, мэргэжилтэн бэлтгэдэг салбарын тэгш, их ойгоор ШУТИС-ийн шагналд нэр дэвшүүлэх буюу шагнал олгоно.



ШУТИС-ийн Ректорын 2017 оны 19 дүгээр сарын  
19-ний өдрийн 19 дугаар тушаалын хавсралт



- 4.6 Тус их сургууль болон тухайн салбар шинжлэх ухааны хөгжүүлэхэд үнэлэхүйц хувь нэмэр оруулсан хамтын ажиллагаатай байгууллагын ажилтныг Ректорын нэрэмжит болон бүрэлдэхүүн, салбар сургуулийн шагналаар шагнаж болно.
- 4.7 Боловсрол, шинжлэх ухаан, технологи, тус их сургуулийг хөгжүүлэх үйл хэрэгт хамт олноо манлайлан үр бүтээлтэй ажиллаж, тодорхой амжилт гаргасан ШУТИС-ийн багш, ажилтныг албан тушаалын нэг сарын үндсэн цалингаас хэтрэхгүй мөнгөн урамшууллаар шагнаж болно.
- 4.8 ШУТИС-ийн Хүндэт өргөмжлөл, ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн болон Ректорын нэрэмжит шагналаар шагнуулахаар 3.3.1, 3.3.2-д дурдсан хурлаас нэр дэвшүүлж, нэр дэвшигчийн товч анкетыг бүрэлдэхүүн, салбар, харьяа сургууль, нэгжийн захирлын зөвлөлийн хурлын тэмдэглэл, газар, албаны хамт олны саналыг хамт тухайн тэмдэглэлт өдөр, ой болохоос 2 долоо хоногоос доошгүй хугацааны өмнө Хүний нөөцийн асуудал хариуцсан захиргааны нэгжид ирүүлнэ.
- 4.9 Хүний нөөцийн асуудал хариуцсан захиргааны нэгж материалыг хянан нэгтгэж, ШУТИС-ийн Захиргааны зөвлөлөөр хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ.
- 4.10 Бүрэлдэхүүн, салбар сургуулийн шагналаар шагнуулах хүнийг тухайн бүрэлдэхүүн, салбар сургуулийн Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ.
- 4.11 ШУТИС-ийн хүндэт өргөмжлөл, ШУТИС-ийн Эрдмийн зөвлөл, Ректорын нэрэмжит болон бүрэлдэхүүн, салбар сургуулийн шагналаар жилд шагнах хүний тоо, дагалдах мөнгөн урамшууллын хэмжээг сургуулийн санхүүгийн нөөц чадавхи, тохиож буй ой, тэмдэглэлт өдөр, онцлог үйл явдалтай уялдуулан ШУТИС-ийн Ректорын зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэж, ШУТИС-ийн Ректорын тушаалаар баталж байна.
- 4.12 ШУТИС-ийн Хүндэт өргөмжлөл, ШУТИС-ийн Эрдмийн зөвлөл, Ректорын нэрэмжит болон бүрэлдэхүүн, салбар сургуулийн шагналаар шагнагдсан гадаадын иргэнд дагалдах мөнгөн урамшуулал олгохгүй.
- 4.13 ШУТИС-ийн Хүндэт өргөмжлөл, ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн болон Ректорын нэрэмжит шагнал, албан тушаалын цалингаар шагнаж урамшуулах тохиолдолд Ректорын тушаал гаргаж, холбогдох зардлыг ШУТИС-ийн төвлөрсөн арга хэмжээний зардлаас, бүрэлдэхүүн, салбар сургуулийн шагналаар шагнахад тухайн бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирлын тушаал гаргаж, холбогдох зардлыг тухайн сургуулиас гаргана.
- 4.14 ШУТИС-ийн Хүндэт өргөмжлөл, ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн болон Ректорын нэрэмжит шагналын өргөмжлөлийг захиргаа, хүний нөөцийн асуудал хариуцсан захиргааны нэгж хариуцан бэлтгэж, хэвлүүлнэ.



## ШИНЖЛЭХ УХААҢ, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН РЕКТОРЫН ТУШААЛ

2024 оны 09 сарын 19 өдөр

Дугаар А/278

Улаанбаатар хот

### ШУТИС-ийн шагналын тоо, дагалдах мөнгөн урамшуулал батлах тухай

ШУТИС-ийн дүрмийн 4.9.15, 4.9.16 дахь заалт, “Шагнал урамшууллын журам”-ын 4.10 дахь заалт, ШУТИС-ийн Ректорын зөвлөлийн 2024 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. ШУТИС-ийн жилд олгох шагналын тоо, дагалдах мөнгөн урамшууллын хэмжээг дараах байдлаар баталсугай. Үүнд:

1.1 Хүндэт өргөмжлөлөөр 5 (тав) хүртэл хүн, дагалдах мөнгөн урамшуулал 1,500,000 (нэг сая таван зуун мянган) төгрөг;

1.2 Эрдмийн зөвлөлийн шагналаар 15 (арван тав) хүртэл хүн, дагалдах мөнгөн урамшуулал 700,000 (долоон зуун мянган) төгрөг;

1.3 Ректорын нэрэмжит шагналаар 25 (хорин тав) хүртэл хүн, дагалдах мөнгөн урамшуулал 500,000 (таван зуун мянган) төгрөг;

1.4 Бүрэлдэхүүн, салбар сургуулийн шагналаар тухайн сургуулийн нийт багш, ажиллагчдын 10 хүртэл хувьтай тэнцэх тооны хүн, дагалдах мөнгөн урамшуулал 300,000 (гурван зуун мянган) төгрөг;

2. Тухайн жилд шагнах хүний тоог батлагдсан тоонд багтаан шийдвэрлэж, тухайн жилийн төсөвт тусган, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төлөвлөлт эрхэлсэн проректор (Л.Баяр-Эрдэнэ), Ректорын ажлын албаны дарга (Н.Ганзориг), Хүний нөөцийн албаны дарга (Д.Мягмарсүрэн), бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирал, ахлах нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

РЕКТОР Т.НАМНАН



367040522